

**“Стандарт ноос” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны
хурлын тэмдэглэл**

2022.03.28.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2022 оны 3 дүгээр сар 28-ны өдөр “Улаанбаатар хивс” ХК-ийн хурлын танхимд 11.10 цагаас эхлэв.

Хурлын ирцийг компанийн ТУЗ-ийн 2022.02.15-ны өдрийн 02\ 2022 тоот тогтоолоор томилогдсон тооллогын комиссын дарга Г.Однаран ирц бүртгэлийн дүнгийн тухай тооллогын комиссын тогтоол 01-ийг танилцуулав. Үүнд хуралд оролцсон хувьцаа эзэмшигч 3, ирц 207022 ширхэг хувьцаа буюу 67,82% болж, Компанийн тухай хуулийн 63.5., болон Компанийн дүрмийн дагуу хурлын ирц хангалттай, хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдэж, хурал даргалах Ё.Энхтөрийг ХЭХ-ын индэрт урив. Хуралд хувьцаа эзэмшигч Л.Цэндээхүү, З.Эрдэнээ, УБ хивс ХК-ийн орлогч захирал З.Мөнхмаа болон ТУЗ-ийн гишүүн Ц.Зоригт, Ё.Энхтөр, Батболд, Баясгалан, Цэвээнравдан нар оролцов.

Ё.Энхтөр : Компанийн ТУЗ-ийн 2-р сарын хурлаас хууль, журмын дагуу ХЭХ-ын даргаар надыг томилсон тул хурал удидаж байна. Улс орон даяар өнгөрсөн жил цар тахлын хүнд үе үргэлжилж ирсэн боловч цагаан сараас хойш нааштай болж байгаа энэ үед өнөөдрийн ХЭХ-ыг хуулийн дагуу хийж байна. Хурал зохион байгуулагчаас та бүхэнд тараасан хурлын материалын дагуу хэлэлцэх асуудал, хурлын дотоод журмаа танилцуулья. Хурлын хэлэлцэх асуудал :

- “Стандарт ноос” ХК-ийн 2021 оны ерөнхий байдал, 2022 оны үндсэн зорилтын тухай.
- “Стандарт ноос” ХК-ийн санхүүгийн тайлан, аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт
- ТУЗ-ийн гишүүдийн сонгууль гэсэн 3 асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаа батлах уу.

Хувьцаа эзэмшигч нар бүгд зөвшөөрөв.

Ё.Энхтөр : Дотоод журмыг хурлын материалд төлөвлөж оруулсан, хурлыг 11.00- 14.00 цагийн хооронд багтааж хийхээр төлөвлөсөн, түүний дагуу дотоод журмаа батлах уу.

Хувьцаа эзэмшигч нар бүгд зөвшөөрөв.

Ё.Энхтөр : Хэлцэх асуудлын дагуу 1-р асуудалдаа шууд орьё, Стандарт ноос ХК-ийн ТУЗ-ийн дарга Ц.Зоригт илтгэл тавьна. Хурлыг шуурхайлж эхлээд хэлэлцэх асуудлуудаа сонсоод дараа нь санал, шүүмжлэлдээ орно, хүн бүр дээр 5 минут гэж тогтох уу.

Бүгд зөвшөөрөв.

Ц.Зоригт : Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдөр буюу 3-р сарын 07-ны өдрийн байдлаар хот, хөдөөгийн үнэт цаасны 36 брокер-дилерийн компанийн харилцагч болох 552 хүн тус компанийн хувьцааг эзэмшиж байгаа бөгөөд компанийн зах зээлийн үнэлгээ нь 183,1 сая төгрөг болж, хувьцааны үнэ, үнэлгээ бараг 2 дахин өссөн.

Баянхонгор дахь “Стандарт ноос” ХК-ийн хуучны барилга, байгууламжууд нь агуулахын зориулалттай байсан учир түүнийг ноос угаах үйлдвэрлэл болгоход ихээхэн анхаарал хүч хөрөнгө зарцуулж, 2015 оноос хойш одоо төслийн ажлын 90 гаруй хувийн гүйцэтгэлд хүрлээ. Тухайлбал, өнгөрсөн жилүүдэд хуучин агуулахын барилгыг үйлдвэрийн байр болгон шинэчлэн засварлаж, шал, хана, дээвэр, цонх хаалга, цахилгаан, техникийн иж бүрэн шинэчлэлт, засварыг хийж, конторын болон амрах байр, ариун цэврийн өрөөнүүдийг шинээр хийж ашиглахад бэлэн болгов.

- Шинээр ноос угаах шугам, 4 тонн/цаг уур гаргах хүчин чадалтай уурын зуух, 17х12 м. хэмжээтэй уурын зуухны барилга барьж, ноос угаахын усны болон уурын шугамнуудыг тавьж, хатаагч барабан, пресс, 40 тн.-ын пүү, хашаа, ажилчдын цайны газар, харуулын байр, ноосны агуулахууд, 4 автомашины гараж, цахилгааны дэд станц, цэвэр усны 10 тонн багтаамжтай усан сангийн барилга, 120 метр урт бохирын шугам, тунгаагуур зэрэг үйлдвэрийн үндэс суурийг тавьж, нийтдээ 737,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг зээлийн эх үүсвэрээр хийгээд байна. Мөн үйлдвэрийн материаллаг баазыг ашиглан орон нутгаас өнгөрсөн жилүүдэд нийтдээ 1200 шахам тн. хонины ноос бэлтгэн ялгаж хивсний үйлдвэрт нийлүүлсэн.

Энэ онд дутуу байгаа зарим ажлуудыг гүйцээж үйлдвэрийг бүрэн ашиглалтанд оруулах зорилго тавин ажиллаж байна. Үүнд :

- уурын зуухны барилгын дотоод тохилжилтын ажлыг хийж, зарим газарт нь шавардлага, тэгшилгээ, эмүльдэх ажлуудыг эцэслэж хийх
- Уурын зуух, усан сан, ноос угаахын шугам, тоног төхөөрөмжүүдийн цахилгаан, уур, усны холболт, хаалтын тоноглолуудыг гүйцээн хийж, туршилт, тохируулга хийх, тунгаагуурын таг, хашлага хийх гм.

- Үйлдвэрийг 6 сар гэхэд ашиглалтанд авах том зорилт тавин ажиллаж байна гэв. Илтгэл нь хурлын материалд байгаа тул товчлов\

Ё.Энхтөр : 2-р асуудлыг материалын дагуу Б.Баясгалан хэлэлцүүлнэ.

Б.Баясгалан : Компани нь өнгөрсөн жил цар тахлын улмаас үйл ажиллагаа явуулаагүй тул өнгөрсөн жилийн аудитлагдсан тайлангаа аудитаар дахин хянуулсан. Харин төсөл хэрэгжүүлэгч "Улаанбаатар хивс" ХК-тай өнгөрсөн жилүүдэд компанийн материаллаг бааз, агуулахуудыг ноос бэлтгэлд ашиглаж ирсэн ашиглалтын зардлыг оны эцэст 2 байгууллагаас ажлын үнэлгээ, зардлын тооцоо нийлж, 59,7 сая төгрөгийг хоорондын өглөг авлагын тооцооноос суутгахаар тохиролцсон. Компанийн санхүүгийн тайланд компани нь үйл ажиллагаа явуулаагүй учраас орлого, мөнгөн хөрөнгө, өмчийн тайланд өөрчлөлт байхгүй, Ер нь ноосны үйлдвэрийг ажилд оруулж хоорондын тооцоог дуусгах шаардлагатай байгааг дурьдав.

Ё.Энхтөр : Дараачийн асуудал бол ТУЗ-ийн сонгууль байгаа, компанийн ТУЗ-өөс хуучин гишүүдийг улираан сонгох саналтай, тиймээс гишүүдийн товч анкет хурлын материалд орсон байна. Тийм ХЭХ-ийн хуралд оролцож байгаа гишүүд болон түрүүнд хэлэлцсэн асуудалтай холбоотой санал, шүүмжлэлдээ орно. Гэхдээ энэ хооронд бас та бүхэн саналын хуудсуудаа бөглөөд тооллогын комисст өгөхийг хүсье. Ингээд илтгэлтэй холбоотой асуудлууддаа орьё.

Л.Цэвээнравдан : Энэ жил үйлдвэр ашиглалтанд орж чадах уу, хир их хугацаа ажил үлдсэн бэ ?

Ц.Зоригт : Ер нь тасралтгүй сайн ажиллавал 2 сарын л ажил байгаа, одоо үйлдвэр дээр өнгийн ноосны үлдэгдэл байгаа, түүгээр эхлүүлж болох юм. Үүнээс гадна ажиллах хүч, эргэлтийн хөрөнгө гээд наад захын асуудлууд ч бас бий, болж өгвөл үйлдвэрээ жигдрүүлээд энэ жилийн ноосоо бүгдийг угаачих санаа бий.

Л.Цэвээнравдан : Ер нь ноос угаах үйлдвэрийн ирээдүй хир зэрэг байна вэ, ашигаа олох болов уу?

Ё.Энхтөр : Монголд жилдээ 30 орчим мтн. ноос бэлтгэдэг, түүний 30 орчим хувь дотоодын хэрэгцээнд бусад нь угаагаад гадагш гаргадаг. Дундговийн хонины ноосны гарц чанар нилээд сайн, бусад аймгийнх үйлдвэрлэлд төдийлөн сайн биш. Хятадууд манай хонины ноосны ноолуурыг ноолууртай хольж ашиглаж ашиг олдог. Ноос бол угааж экспортлохоос гадна цаашдаа самнах, зэрэх гээд хөдөлмөр шингээж гаргавал бидэнд хэрэгтэй.

Ц.Зоригт : Манай үйлдвэр ерөнхийдөө 500-600 тн. угаачих байх, яаж ажиллуулахаас их хамаарна, түүнээс 300 орчим тн. дотоодод хэрэглэнэ гэж тооцож байгаа. Нийтдээ 1 ээлжээр бол 20 орчим хүний ажлын байр бий болно, түүнээс ядаж 3-4 хүн нь мэргэжилтэй боловсролтой, найдвартай ажиллах хүн ховор байна.

Ё.Энхтөр : Тооллогын комиссын шийдвэр гасан тул, санал шүүмжлэлээ үүгээр дуусгавар болгох уу ?

Бүгд зөвшөөрөв.

Тооллогын комиссын дарга Г.Однаран санал хураалтын үр дүнгийн тухай тооллогын комиссын тогтоол №2, 3, 4-ыг уншиж танилцуулав.

Ё.Энхтөр : Санал хураалтын үр дүнгээр хурлаас гарах тогтоолын төслийг бүрэн дэмжсэн байна, "Компанийн үйл ажиллагааны үр дүнгийн тухай" 1-р тогтоол, "ТУЗ-ийн гишүүдийг батлах тухай" 2-р тогтоол, "ТУЗ-ийн хараат бус гишүүдийг батлах тухай" 3-р тогтоолуудын төслүүдийг батлах уу ?

Бүгд дэмжин зөвшөөрч гар өргөв.

Ё.Энхтөр : Өнөөдрийн хурлын хэлэлцэх асуудал дуусч, төлөвлөсний дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын 3 тогтоол гарч асуудлуудаа шийдвэрлэлээ. Хурлын үр дүнгээр компанийн үйл ажиллагааг энэ ондоо эхлүүлэх том зорилт үлдлээ. Хуралд идэвхитэй оролцсон та бүхэнд талархал илэрхийлж энэ хурлаа хааж байна. Бүгдэд амжилт хүсье.

Хурал 14.00-д дуусав.

Хурлын протокол хянасан:

Хурлын дарга :

Ё.Энхтөр

Хурлын протокол хөтөлсөн:

Г.Однаран

